

**БУЛГАН АЙМГИЙН ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН  
САНААЧЛАГЫН ДЭД ЗӨВЛӨЛИЙН 2023 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН**

**БАТЛАВ.**  
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ,  
ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД  
БАЙДЛЫН САНААЧЛАГЫН ДЭД ЗӨВЛӨЛИЙН  
ДАРГА *[Signature]* Д.ЖАРГАЛСАЙХАН

Д/д	Үйл ажиллагааны чиглэл	Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
1	<b>Судалгаа, мэдээ, тайлан гаргах ажлын хүрээнд</b>		
1.1	<p>Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн шилжллт, хөдөлгөөний мэдээллийг <a href="http://www.bulgan.gov.mn">www.bulgan.gov.mn</a> цахим хуудсаар дамжуулан тухай бүрт нь шинэчилж мэдээллэх</p>	<p>2024 оны 2 дугаар сарын байдлаар аймгийн хэмжээнд ашигт малтмалын ашиглалтын 79 аж ахуйн нэгжийн 49868.95 га, хайгуулын 33 аж ахуйн нэгжийн 174706.5 га талбайд тусгай зөвшөөрөл олгогдсон байна. Үүнтэй холбогдуулан цахим хуудсанд ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн мэдээллийг тухай бүрт нь байршуулан ажиглаж байна.</p>	100
1.2	<p>Орон нутгийн төсөвт хүлээн авсан татвар, төлбөр, хандив, дэмжлэгийн мэдээг гарган, санхүү татварын мэдээлэлтэй тулган баталгаажуулсны үндсэн дээр программд шивж оруулан нэгдсэн дүнг ОУИТБСА-ын албанд хүргүүлэх</p>	<p>2023 онд аймгийн Засаг дарга болон Бүрэгхангай, Дашинчилэн сумын Засаг дарга нар уул уурхайн 9 аж ахуйн нэгжтэй байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай хамтын ажиллагааны гэрээг байгуулж, 38 хүүхдийн сургалтын төлбөр болгох 196.5 сая төгрөгийг аймгийн Засаг даргын тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэхээр тогтож, одоогийн байдлаар 36 хүүхдийн сургалтын төлбөр 186.0 сая төгрөгийг төвлөрүүлээд байна. Бүрэгхангай сум 2023 онд уул уурхайн үйлдвэрлэл эрхлэгч 8 аж ахуйн нэгжтэй орон нутгийн дэд бүтэц, ажлын байр нэмэгдүүлэх, хандивын асуудлаар гэрээ байгуулж, 516.5 сая төгрөгийг төвлөрүүлэв.</p>	90
1.3	<p>Байгаль хамгаалах зардлын 50 хувийг тусгай дансанд төвлөрүүлсэн байдал, түүний зарцуулалт буцаан төлөлтийн мэдээг аж ахуйн нэгж бүрээр гаргах</p>		-
1.4	<p>Байгаль орчны нөхөн сэргээлтийн талаарх мэдээ, тайланг аж ахуйн нэгж бүрээр гаргах</p>	<p>2023 онд Бүрэгхангай суманд уул уурхайн олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа "Монголимет" ХХК, "ГЕНБ" ХХК, "Өгөөж баян хангай" ХХК, "Мөнх нархан орд" ХХК, "Гэрэлт шинэчлэл" ХХК, "Глатинум Ланд" ХХК, "Хос хас" ХХК, "Хан тэнгэрийн дуудлага" ХХК, Дашинчилэн сумын "Батродорс майнин" ХХК нийт 9 аж ахуйн нэгж байгаль орчны</p>	90

		Менеджментийн төлөвлөгөөний дагуу техникийн нөхөн сэргээлт 54.68 га талбайд төлөвлөгдсөнөөс 64.5 га талбайд, Биологийн нөхөн сэргээлт 25.65 га талбайд төлөвлөгдсөнөөс 33.75 га талбайд хийсэн байна. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд эвдэрч, эзэнгүй орхигдсон талбайд техникийн нөхөн сэргээлт 30.58 га талбайд төлөвлөгдсөнөөс 31.7 га талбайд хийж гүйцэтгэжээ.	
1.5	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, тэдгээрт оруулсан өөрчлөлт, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлаг гаргах	Уул уурхайн олборлолтын байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг 10 аж ахуйн нэгж байгууллага тайлангаа хамгааллаа.	100
1.6	Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн хэрэгжилтийн мэдээ, тайлан гаргах, <a href="http://www.iitodogee.mn">www.iitodogee.mn</a> цахим хуудсанд тавих	Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалтын дагуу 9 аж ахуйн нэгжтэй Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх ажлын байр нэмэгдүүлэх тухай гэрээ байгуулж, гэрээний үнийн дүнг аймгийн Засаг даргын Тамгын газрын нэмэлт дансанд 196.0 сая төгрөг төвлөрүүлэхээс 186.0 сая төгрөгийг төвлөрүүлэн элсэлтийн ерөнхий шалгалтад өндөр оноо авсан 37 оюутанд 1 жилийн сургалтын төлбөрийн батламжийг гардуулан өгч ажиллаа.	90
2	<b>Иргэдэд нээлттэй шл мод мэдээлэх, олон талын оролцоотой хэлэлцүүлэг өрнүүлэх ажлын хүрээнд</b>		
2.1	ОУИТБС-ын аймгийн дэд зөвлөлийн хурлыг зохион байгуулах	2023 оны 04 дүгээр сард аймгийн дэд зөвлөлийн ажлын хэсгийн ахлагчаар ахлуулсан ажлын хэсэг 2023 оны батлагдсан төлөвлөгөөний дагуу ажлын хэсэг хурлыг зохион байгууллаа.	100
2.2	Бүрэгхангай сумын иргэд болон уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн дунд ОУИТБС-ын үйл ажиллагаа болон хамтын ажиллагааны талаар уулзалт зохион байгуулах	2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр Бүрэгхангай сумын ЗДТГ, БОАЖТ, аймгийн Экологийн Цагдаагийн алба хамтран уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн дунд ОУИТБС болон нийгмийн харилцлалтын гэрээнд тусгах хамтын ажиллагааны уулзалтыг зохион байгуулж, суманд үйл ажиллагаа явуулж байгаа болон явуулах 14 аж ахуйн нэгж амжилттай оролцож санаа болдоо хэлэлцлээ.	100
3	<b>Хамтын ажиллагаа, түншлэлийг хөгжүүлэх, чадаах бэхжүүлэх ажлын хүрээнд</b>		
3.1	Төр, компани, иргэний нийгмийн харилцан ойлголцол, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор гэрээ байгуулах	Аймгийн Засаг дарга болон Бүрэгхангай, Дашинчилэн сумын Засаг дарга нар уул уурхайн 9 аж ахуйн нэгжтэй байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай хамтын ажиллагааны гэрээг 2023 оны 5 дугаар сард байгуулан ажиллаа.	100
3.2	Уул уурхайн компаниудын үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцах	Бүрэгхангай сумын нутагт Уйлант нэртэй газарт иргэд гар аргаар ашигт малтмал олборлож байсан үйлдлийг зогсоож, аймгийн Цагдаагийн газраас байнгын пост гарган ажиллуулж, Байгаль орчин, аялал	100

		<p>жуулчлалын газраас эвдрэлд орсон 2 га газарт техникийн нөхөн сэргээлт хийлгэхээр мэргэжлийн байгууллалтай гэрээ байгуулан ажиглаж байна. Хууль бусаар ашигт малтмал олборлож байсан болон холбогдох бичиг баримтгүйгээр үйл ажиллагаа явуулж байсан тусгай зөвшөөрөл эзэмшигч 3 аж ахуйн нэгж, зам барилгын ажил гүйцэтгэгч 4 аж ахуйн нэгж, 2 нөхөрлөл, 6 иргэн шалгалтад хамрагдсанаар илэрсэн зөрчлийг арилгуулж, ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 4 аж ахуйн нэгжид Зөрчлийн тухай хуулиар 40.0 сая төгрөг, 3 нөхөрлөл, Түгээмэл тархацтай ашигт малтмал тусгай зөвшөөрөлгүй олборлосон 3 аж ахуйн нэгж, 6 иргэнд Зөрчлийн тухай хуулиар 12.2 сая төгрөгийн шийтгэл ногдуулж, 4750.0 мянган төгрөгийн нөхөн төлбөр ногдуулж, 90 м.куб элс хурааж улсын орлого болголоо.</p>	
3.3	Нийгмийн харилцлалтын хүрээнд Байгуулсан гэрээг дүгнэх	<p>2023 онд байгуулсан нийгмийн харилцлалтын гэрээг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит XXIV хуралдаанаар хэлэлцүүлэн дүгнэхээр болсон.</p>	100
<b>4</b>		<b><i>Дэд зөвлөлийн хурлаар асуудал хэлэлцэх</i></b>	
4.1	Тайлан мэдээг нэгтгэн гаргаж, дүнг дэд зөвлөлийн хуралд танилцуулан цаашид хэрэгжүүлэх ажлыг төлөвлөж, жилийн ажлын төлөвлөгөөнд тодотголоор нэмэлт өөрчлөлт, оруулж ажиллах.	<p>2024 онд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажилд эвдэрч, эзэнгүй орхигдсон газрыг нөхөн сэргээх ажлыг 40 га талбайд хийгдэхээр төлөвлөгдөөд байна.</p>	-

**БУЛГАН АЙМГИЙН ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧЛАГЫН ДЭД ЗӨВЛӨЛ**